




ХӨРС СУДЛАЛЫН ХОЛБОО



МОНГОЛЫН ХӨРС СУДЛАЛ

2016 (01)

Mongolian Journal of Soil Science



Улаанбаатар 2016

ХӨРС СУДЛАЛЫН ХОЛБОО

МОНГОЛЫН ХӨРС СУДЛАЛ

2016 (01)

MONGOLIAN JOURNAL OF SOIL SCIENCE

Улаанбаатар 2016

Соёлын наалдуу орхын

Редакцийн зөвлөл

Ерөнхий эрхлэгч: Доктор О.Батхишиг

Нарийн бичгийн дарга: Доктор Н.Нямсамбуу

Хүндэт гишүүд:
Академич Д.Доржготов
Проф. С.Ичинхорлоо
Проф. А.Чойжамц
Проф. Д.Аваадорж
Доктор Д.Батбаяр

Гишүүд:
Доктор Ш.Пүрэвсүрэн
Доктор Я.Баасандорж
Доктор А.Буянбаатар
Доктор Ч.Лхагвасүрэн
Доктор Б.Одгэрэл
Доктор Д.Туул
Доктор Б.Ундрах-Од
Доктор А.Энхтөр
Доктор Б.Энхтуяа

Хэвлэлийн эхийг: Г.Бямбаа

Бүтээлийг Монголын “Хөрс судлалын холбоо”-ноос эрхлэн гаргав.

Хамтран ажилласан: ШУА Газарзүй-Геоэкологийн хүрээлэн Хөрс судлалын салбар, Монгол улсын их сургууль, ХААИС-ийн Агроэкологийн сургууль, Дарханы Ургамал Газар тариалангийн хүрээлэн, Ховд их сургууль

ISBN 978-99973-48-95-1

Хэвлэлийн компани “Удам соёл” ХХК

Гарчиг

Хотгорын нөлөө ба хөрсөн бүрхэвч	9
Д.ДОРЖГОТОВ	
Монгол орны хөрсний ангилал-2016.....	18
О.БАТХИШИГ	
Монголын дорнод хэсгийн элсэнцэр Хархүрэн хөрсний ус-физик шинж, чийгийн горим	32
Д.БАТБАЯР	
Хараа голын сав газрын хөрсний хээрийн чийг багтаамж	43
Г.БЯМБАА, О.БАТХИШИГ	
Экийн голын хөрсний давсжилт.....	51
Ж.МАНДАХБАЯР	
Целжилтийн мониторингийн талбайн хөрсний үржил шимиийн онцлог.....	62
Я.БААСАНДОРЖ, Р.ДЭЛГЭРЦЭЦЭГ, А.ХАУЛЕНБЕК	
Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын “Овоотын” нүүрсний уурхайн хөрсөн бүрхэвч	69
Т.МӨНХБАТ	
Хантайн нурууны ойн хөрсний физик, химийн шинж чанарын судалгаа.....	76
Ц.БАТЧУЛУУН	
Хээрийн бүсийн хөрсний экологи-эдийн засгийн үнэлгээ, Говь-сүмбэр аймгийн жишээн дээр.....	85
Т.ОЮУНЧИМЭГ, Б.САЯХҮҮ Б.МИНЖМАА, Г.НЯМДОРЖ, Х.ЛХАГВАСҮРЭН	
Монгол орны тариалангийн газрын ашиглалт, хөрсний элэгдэл эвдрэл.....	94
Н.НЯМСАМБУУ, Д.ИХБАЯР	
Ховд хотын цэвэрлэх байгууламж орчмын нутгийн хөрсний хүнд элементийн бохирдлын судалгаа.....	102
Ч.ЛХАГВАСҮРЭН, О.БАТХИШИГ, Д.БАТЦЭЦЭГ	
Эүүнхангай сумын төв орчимд тархсан хөрсний төлөв байдал, элэгдэл.....	111
А.ЭНХТӨР, Б.НЯМБАР	

Хээр, говийн бүсийн хөрсний тархалт, шилжилтийн онцлог	122
П.ОЮУНБАТ, Г.ЭЛБЭГЗАЯА	
Монгол орны тариалангийн зарим хөрсний шим тэжээлийн бодисын хангамж.....	131
А.БУЯНБААТАР	
Хөрсний зарим шинж чанарт бордооны нөлөөг судалсан дүн.....	140
Б.ОДГЭРЭЛ	
Тариалангийн төв бүсийн Хүрэн хөрсний фосфорын агуулалтыг нэмэгдүүлэх боломж.....	146
Г.СОЛОНГО	
Хөрсний нүүрстөрөгч, азотын харьцаанд хөрс боловсруулалт, сэлгээний нөлөө	153
Д.АРИУНЦЭЦЭГ, Л.ДАВАА, Г.СОЛОНГО	
Хүрэн хөрсний үргжил шимд бордооны нөлөө	160
Д.ТУУЛ, Б.БАЯРСАЙХАН	
Хучилгатай талбайн Хүрэн хөрсний ялзмаг ба бордооны нөлөө.....	164
Д.ЗАНДРААГОМБО, Д.ТУУЛ	
Хөрсний агрохимийн шинж чанарт байгалийн эрдэс бодисын нөлөө.....	168
Д. ГАНТУЯА, Д. ТУУЛ	
Хучлагатай тариалангийн Хүрэн хөрсний бичил биетний харьцуулсан судалгаа.....	172
Б.ДЭЛГЭРМАА, О.СҮНЖИДМАА	
Хөрс.....	177
Ш.ПҮРЭВСҮРЭН.....	177
“Хөрсний нөөцийг хамгаалах ба тогтвортой менежмент” сэдэвт Азийн Хөрсний Нөхөрлөлийн зөвлөлдөх уулзалт	180
Bangkok communiqué	181
Зүүн ба Зүүн-хойд Азийн Хөрс Судлалын Холбооны Олон улсын 12-р бага хурал	183
Монголын хөрс судлаачдын анхдугаар чуулга уулзалт	184

ЦӨЛЖИЛТИЙН МОНИТОРИНГИЙН ТАЛБАЙН ХӨРСНИЙ УРЖИЛ ШИМИЙН ОНЦЛОГ

Я.БААСАНДОРЖ^{1*}, Р.ДЭЛГЭРЦЭЦЭГ¹, А.ХАУЛЕНБЕК²

¹ Газрын нөөц газар ашиглалтын салбар, ГГХ

² Цөлжилтийн судалгааны салбар, ГГХ

Soil fertility specific of desert monitoring area

Over the thousands of years, Mongolian livestock farming has been evolved and adapted to climate and environment changes. But, the last hundred years, climate is changing rapidly as well as, inappropriate human activities such as rapid increases of livestock number, mining activities, and rangeland overgrazing which is contributing desertification in Mongolia. In this paper, we included the result of soil's physical and chemical characteristics in the desertification monitoring study points.

Түлхүүр үгс: мониторингийн судалгаа, хөрсний хэв шинж, хими, физик шинж чанар

Оршил

Манай оронд хөрс судалгааны ажил ХХ зууны эхэн үеэс эхэлсэн харьцангуй шинэ салбар юм. Тэдгээрийн дотор Оrosын хөрс судлагч Н.Д.Беспаловын удирдлагаар 1940-өөд оны эхэн үед Монгол орны хөрсөн бүрхэвчийг судлах экспедицийн судалгаа хийгдэж хөрсний гарал үүсэл, үржил шимийн зарим үзүүлэлтүүдийг тогтоосон байдал.

Харин 1960-аад оны эхлэн үеэс үндэсний хөрс судлагчид бэлтгэгдэж, Монгол орны хөрсний гарал үүсэл, тархалт, зүй тогтол, хөрсний үржил шимийн түвшин, физик-химийн шинж чанарын үзүүлэлтүүдийг судлан түүнийг хөдөө аж ахуйд ашиглах зориулалтыг тогтоох, зураглах иж бүрэн судалгааны ажил хийгдэж ирсэн нь өнөө үед ихээхэн ач холбогдолтой бүтээл болж байна.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын дулаарал, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс элэгдэж эвдрэх, цөлжих, дорийтох нь манай орны байгалийн аль ч бус нутгийг хамарсан байгаль орчинд серөг үзэгдэл болж байгааг олон судалгааны дун харуулж байна.

Монгол орны газар нутгийн хөрсний элэгдэл эвдрэлийн ерөнхий төлөв байдлын судалгаагаар нийт нутаг дэвсгэрийн 77.8% элэгдэж эвдэрсэн хөрстэйн дотор 14.1 хувь усаар угаагдаж, 58.6 хувь нь ус салхины хавсарсан ба 5.1 хувь нь дан ганц салхины үйлчлэлд нэрвэгдэж (Аваадорж, 2001) байгаа тогтоосон байна.

*BAASANDORJ Yadambaatar. Institute of Geography-Geoecology, Mongolia

"Төв Монголын загвар нутгийн хүрээн дэх цөлжилтийн мониторингийн судалгаа" сэдэвт суурь судалгааны ажлын хүрээнд цөлжилтийн төлөв байдлын мониторингийн судалгааг явуулж, хөрсөн бүрхэвчийн төлөв байдал, үржил шимийн түвшин тогтоосон үр дүнг энэхүү өгүүлэлд оруулав.


Судалгааны аргазүй.

Хээрийн судалгаанд мониторингийн цэгүүдийн газрын гадаргын төлөв байдлыг тодорхойлон, хөрсний зүсэлт тавьж, морфологи бичиглэл хийж, хөрсний үргжил шимийг тодорхойлох дээжийг 0-20 см-ийн гүнээс дээж авч хөрсний механик бүрэлдэхүүн болон агрохимийн үндсэн үзүүлэлтүүдийг MNS 3310:1991 стандарт болон бусад аргазүйн дагуу лабораторийн задлан шинжилгээг хийж тодорхойлов.

Судалгаа явуулсан газар.

Төв аймгийн Эрдэнэсант сум, Өвөрхангай аймгийн Бүрд сум, Булган аймгийн Гурванбулаг, Рашаант сумдын нутагт тархсан хөрсний хэв шинжийг төлөөлүүлэн нийт 16 цэгийг сонгон авч хөрсний үргжил шимийн төлөв байдлыг тогтоох мониторингийн судалгааг явууллаа.

Судалгаа явуулж буй нутаг дэвсгэр хөрс-газарзүйн мужлалаар Орхон-Туулын тойротг багтаж бөгөөд уулс нуруудын ар хажуугийн хэсэгхэн газруудад ой алаг цоог тохиолдохын зэрэгцээ Уулын Нугын Хэр, нам уулс, тал газар, Толгодын Хар Хүрэн, Хүрэн хөрс зонхилон тархсан (Доржготов, 1976).



Зураг 1. Судалгдаа хийж буй мониторингийн иэсийн байршил

Мониторинг судалгаанд 930262 га талбай хамрагдсанаас ойн хөрс 11.5 га буюу 0.12%, уулын хар хүрэн хөрс 65.7 мян.га буюу 7.07%, уулын хүрэн хөрс 311.4 мян.га буюу 33.48%, хээрийн хүрэн хөрс 337.3 га буюу 36.26%, нутын хөрс 35.7 мян.га буюу 3.84%, аллювийн нутын хөрс 109.7 мян.га буюу 11.79%, элсэн хөрс 69.02 мян.га буюу 7.45%-ийг тус тус эзэлж байна.

Ойн хөрс. Бид Төв аймгийн Эрдэнэсант сумын Цүгээлийн амны зүүн энгэр, Хөгнө Хан уулын ар, далайн түвшнээс 1521 метрт байрлах газруудад хөрсний зүсэлт хийв. Мониторингийн цэгүүдийн хөрсний өнгөн хэсэг нь ургамлын үндсээр торлогдсон ширгээр хучигдсан.

Ойн хөрсний төлөв байдал, үргжил шимиийн онцлогийг 10-р зүсэлтийн хөрсний бичиглэл болон лабораторийн задлан шинжилгээний дунгээр үзүүлэв.

А 0-22 см. Чийг ихтэй, хар бараан өнгөтэй, ургамлын бүдүүн, нарийн үндэс ихтэй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, давсны хүчилд буцлахгүй.

АВ 22-47 см. Чийг ихтэй, хар бараан өнгөтэй, ургамлын үндэс дунд зэрэг, том чулуутай, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, давсны хүчилд буцлахгүй, шилжилт аажим.

В 47-56 см. Чийгтэй, улаан хүрэн өнгөтэй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, ургамлын үндэс мэр сэр, том чулуу ихтэй, давсны хүчилд сул буцална, шилжилт өнгөөр тод.

Ойн хөрсний ялзмагийн агуулалт нь 6.13% буюу өнгөн хэсэгтээ их байгаа нь ургамлын органик үлдэгдэл задарч ялзмагжих үйл явц идэвхитэй явагддагтай холбоотой. 100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфор 4.32 мг, кали 29 мг, шингээгдсэн сууриудын нийлбэр 34 мг, хөрсний урвалын орчин pH 6.31 буюу сувалтар хүчиллэг шинжтэй байна. Хөрсний физик шаврын агуулалт 24.8%, доод гүндээ 22.7% буюу хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

Уулын хар хүрэн хөрс. Энэ хэв шинжийн хөрс нь уулын ар хажуу, энгэр бэл хэсгээр бага хэмжээний талбай эзлэн тархах бөгөөд нэлээд чийглэгдүү, үйрмэг чулуу баатай, гол төлөв хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байдаг. Хөрс үүсгэгч эх чулуулаг нь элюви, делювийн сайрархаг нимгэн хурдсаас тогтоно. Уулын хар хүрэн хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрсний шинж чанарыг 3-р зүсэлтийн бичиглэлээр төлөөлүлүн авч үзлээ.

Булган аймгийн Гурванбулаг сум, Авзага хайрханы хойд энгэр, далайн түвшнээс дээш 1671 метр, хялгана, хиаг, ерхөг, үнэгэн сүүл, тайжийн жинс, хазаар өвс зэрэг зонхилох ургамалтай.

А 0-26 см. Чийгтэй, хар хүрэн өнгөтэй, ургамлын нарийн үндэс ихтэй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, бөөмөрхөг бүтэцтэй, давсны хүчилд буцлахгүй.

В 26-47 см. Өлөн чийгтэй, хүрэн өнгөтэй, ургамлын үндэстэй, дунд зэргийн чулуу ихтэй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, давсны хүчилд буцлахгүй, шилжилт аажим.

Үүлын Хар Хүрэн хөрсний ялзмагийн агуулалт 3.65%, 100 гр хөрсөнд хөдөлгөөнт фосфор 3.63 мг, кали 24 мг, шингээгдсэн сууриудын нийлбэр 32 мг-экв байгаа нь тухайн хөрс үржил шимиийн түвшин сайн болох нь шинжилгээний дүнгээс харагдаж байна. Хөрсний урвалын орчин pH 6.61 хүчтэй хүчиллэг шинжктэй байна. Хөрсний 0-28 см-ийн гүнд физик шаврын агуулалт 27.1%, доод гүндээ 25.3% буюу хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

Үүлын хүрэн хөрс. Энэ хэв шинжийн хөрсний босоо бүсшилийн доод бүслүүрийг үүсгэж 1100-2400 метр хүртлэх үнэмлэхүй өндрийн түвшинд тархах бөгөөд түүний тархалтын доод хил нь уул толгодын бэл хормойн геоморфологийн хилээр тод зааглагдана. Үүлын хажуугийн эгц налуу, зүг зовхисын байдлаас шалтгаалж ялзмагт үеийн зузаан, ялзмаг хуримтлалын хэмжээ, хөрсний тогтвортайлт харилцан адилгүй байна. Үүлын хүрэн хөрсний шинж чанарын онцлогийг 2-р зүсэлтийн бичиглэлээр төлөөлүүлэн үзүүлэв.

Булган аймгийн Гурванбулаг сум, Авзага хайрханы урд өвөр, далайн түвшнөөс 1480 м, уулын урд хормойд хялгана, нарийн харгана, хиаг, бүйлс, шарилж зэрэг зонхилох ургамалтай.

А 0-22 см. Өлөн чийгтэй, хүрэн өнгөтэй, өнгөндөө жижиг хайрга чулуу ихтэй, ургамлын нарийн үндэс ихтэй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, давсны хүчилд хүчтэй буцална, өнгөөр шилжилт тод.

В_{ca} 22-58 см. Өлөн чийгтэй, цайвар шаргал өнгөтэй, ургамлын үндэс үзэгдэхгүй, жижиг үйрмэг чулуу ихтэй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, давсны хүчилд хүчтэй буцална.

Үүлын Хээрийн Хүрэн хөрсөнд ялзмагийн агуулалт дунджаар 2.45%, 100 гр хөрсөнд хөдөлгөөнт фосфор 2.49 мг, кали 19 мг, шингээгдсэн сууриудын нийлбэр 22 мг-экв байгаагийн дийлэнх хувийг кальцийн катион давамгайлна. Хөрсний урвалын орчин pH 7.45 шүлтгэг шинжктэй байна. Хөрсний 0-22 см-ийн гүнд физик шаврын агуулалт 25.8%, доод гүндээ 22.4% буюу хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

Хээрийн Хүрэн хөрс. Хээрийн хүрэн хөрсөн дэх хээрийн ургамалшил тачир сийрэг, ойролцоогоор хөрсний 30-50 хувь нь ургамлаар бүрхэгдсэн байна. Хөрсний үе давхарга агаарын хур тундасаар чийглэгддэг тул зуны борооны үеэс бусад хугацаанд хөрс их хуурай байдаг. Хүрэн хөрсний ялзмагийн агуулалт ерөнхийдөө бага боловч хөрсний механик бүрэлдэхүүнээс хамаарч нилээд хэлбэлзэлтэй. Энэ хэв шинжийн хөрс нь хамгийн өргөн тархалттай бөгөөд хөдөө аж ахуйн салбарт хамгийн их ашиглагддаг. Хүрэн хөрсний шинж чанарыг зүсэлт 01, 11-д хийсэн бичиглэлээр үзүүлэв.

Булган аймаг, Гурван булаг сум, Амгалын гол, далайн түвшнөөс 1189 метр, улалж, хялгана, хиаг, дэрс, шарилж тархсан, голын хөндийн тэгш өндөрлөг, жижиг чулуухаг бүхий элсэн гадаргатай.

А 0-13см. Өлөн чийгтэй, цайвар хүрэн өнгөтэй, ургамлын үндэс мэр сэр, жижиг үйрмэг чулуутай, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, давсны хүчилд буцлахгүй, шилжилт өнгөөр тод.

AB 13-25см. Өлөн чийгтэй, цайвар хүрэн өнгөтэй, ургамлын нарийн гол үндэстэй, жижиг үйрмэг чулуутай, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, давсны хүчилд сул буцална, шилжилт өнгөөр аажим.

B_{ca} 25-63см. Хуурай, бор саарал өнгөтэй, ургамлын нарийн үндэс мэр сэр үзэгдэнэ, жижиг дунд зэргийн хайрга чулуу ихтэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, давсны хүчилд хүчтэй буцална, шилжилт аажим.

Төв аймгийн Эрдэнэсант сум, тасархай худаг, далайн түвшнээс дээш 1320 метр, уулсын хоорондын тал хөндий, тэгш гадаргатай, үлийн оготнын нух элбэгтэй, үмхий шарилж, хазаар өвс зэрэг зонхилох ургамалтай, хөрсний өнгөндөө сул нунтаг шороо ихтэй.

А 0-28см. Өлөн чийгтэй, цайвар хүрэн өнгөтэй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, ургамлын үндэс дунд зэрэг, сул бөөмөрхөг бүтэцтэй, нягтавтар, жижиг сайр чулуутай, давсны хүчилд буцлахгүй.

AB 27-47см. Хуурай, цайвар шаргал өнгөтэй, алаг цоог бор туяатай, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, ургамлын хаяа мэр сэр үзэгдэнэ, нягтавтар, давсны хүчилд сул буцална, шилжилт өнгөөр тод, хил зааг долгиорхог.

B_{ca} 47-87см. Хуурай, шаргал өнгөтэй, ургамлын үндэс үзэгдэхгүй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, жижиг хайрга чулуутай, давсны хүчилд хүчтэй буцална, доод дарагдмал элс маягийн шинжтэй байв.

Хээрийн Хүрэн хөрсний ялзмаг агуулалт дунджаар 2.52%, 100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфор 1.88 мг, кали 16 мг, шингээгдсэн сууриудын нийлбэр 18 мг-экв, хөрсний урвалын орчин pH 7.33 шүлтлэг шинжтэй байна. Хөрсний 0-28 см-ийн гүнд физик шаврын агуулалт 24.2%, доод гүндээ 26.7% буюу хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

Аллювийн нугын хөрс. Голын хөндий, түүний татмын дэнж, нуур цөөрмийн хөвөө орчмын нам дор чийглэг газар тархана. Энэ хэв шинжийн гол шинж нь ус чийг элбэгтэй, үетэн-алаг өвст ургамлын бүрхэц 60-80% хүрнэ. Аллювийн нугын хөрс нь дунд болон хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрс зонхилон тархах бөгөөд түүний үе давхаргад янз бүрийн зузаантай үеүүд тод ажиглагдах бөгөөд тэдгээр нь усны үйлчлэлийн ул мөр юм. Аллювийн нугын хөрсний шинж чанарыг 4, 8-р зүсэлтийн хийсэн бичиглэлээр үзүүлэв.

Булган аймгийн Раашаант сум, Элсэн тасархай орчмын нутаг. Ургамлан нэмрөгт хиаг, хазаар, гичгэнэ, ширэг улалж зэрэг зонхилено. Төвгөрдүү мезо гадаргатай, ерөнхийдөө нилээн хуурайшсан шинжтэй.

А 0-12см. Өлөн чийгтэй, сааралдуу бараан өнгөтэй, дунд шавранцар механик бүрэлдэхүүнтэй, ургамлын нарийн дунд зэргийн үндэс ихтэй, үрлэн бүтэцтэй, жижиг үйрмэг чулуутай ихтэй, доод үедээ шилжих шилжит өнгөөр тод.

А 12-48 см. Чийгтэй, бараан сааралдуу өнгөтэй, ургамлын нарийн үндэс мэр сэр, нягтавтар, үрлэн бүтэцтэй, дунд шавранцар механик бүрэлдэхүүнтэй, доод талдаа бүдүүн элсний ширхэг ихтэй, давсны хүчилд сувалтар буцална, шилжилт өнгөөр тод.

AB_{ca} 48-80см. Нойтон, бараан өнгөтэй, жижиг сайр чулууны хэмжээ ихтэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, ургамлын үндэс үзэгдэхгүй, давсны хүчилд буцлана, цааш ухах боломжгүй.

Булган аймаг, Гурванбулаг сум, Тарнын голын урд талын элсэн хөрсөнд хийсэн 04-р зүсэлтийн бичиглэл. Энэ хөрс нь далайн түвшнээс дээш 1114 метр байрлах, харгана, хялгана, бага хургалж, хиаг зэрэг ургамалтай.

А 0-32 см. Хуурай, цайвар хүрэн өнгөтэй, элсэн механик бүрэлдэхүүнтэй, ургамлын нарийн үндэс ихтэй, нягт, бөөмөрхөг бүтэцтэй, жижиг үйрмэг чулуутай, давсны хүчилд буцлахгүй, шилжилт өнгөөр алгуур.

AB 32-46 см. Хуурай, хүрэн өнгөтэй, ургамлын нарийн үндэс бага зэрэг, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, том жижиг чулуу ихтэй, давсны хүчилд сувалтар бургина.

Аллювиийн Нууын Дунд Шавранцар хөрсөн дэх ялзмагийн хэмжээ 2.84%, 100 гр хөрсөнд хөдөлгөөнт фосфор 2.11 мг, кали 23 мг, шингээгдсэн сууриудын нийлбэр 23 мг-экв, хөрсний урвалын орчин pH 8.16 шүлтлэг шинжтэй байна.

Аллювиийн Элсэн хөрсний ялзмагийн агуулалт нь 0.92%, 100 гр хөрсөнд хөдөлгөөнт фосфор 1.57 мг, кали 14 мг, шингээгдсэн сууриудын нийлбэр 12 мг-экв, хөрсний урвалын орчин pH 7.43 шүлтлэг шинжтэй байна. Хөрсний физик шаврын агуулалт 34.6% дунд шавранцар, элсэн хөрсөндөө физик шаврын агуулалт 8.3% байна.

Дүгнэлт

Цэлжилтийн мониторингийн судалгааны 16 цэгт ойн хөрс, уулын хар хүрэн хөрс, уулын хүрэн хөрс, хүрэн хөрс, аллювиийн нугын хөрс, элсэн хөрсний хэв шинж тархсан байна. Эдгээр хөрсний ялзмагийн хэмжээ ойн хөрсөнд 6.13%, уулын хар хүрэн хөрсөнд 3.65%, уулын хүрэн хөрсөнд 2.45%, хээрийн хүрэн хөрсөнд 1.47-2.49%, аллювиийн нугын дунд шавранцар хөрсөнд 2.84%, аллювиийн элсэнцэр хөрсөнд 1.43%-ийн агуулалттай байна. Харин мониторингийн судалгааны цэгүүдэд хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрс тархсан байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

- Аваадорж Д, (2001). Монгол орны бэлчээр ашиглалт, экологийн онцлог. "Нүүдэлчид ба бэлчээр ашиглалтын өнөөгийн тулгамдсан асуудал". Бага хурлын эмхтгэл. Улаанбаатар.
- Аваадорж Д, Бадрах С, Баасандорж Я. (2006). Бэлчээрийн хөрсний физик шинж чанар ба ургамлан нэмрөг, тэдгээрийн өөрчлөлт. Улаанбаатар, х 215.
- Доржготов Д. (1976). Монгол орны хөрс-газарзүйн мужлал. Улаанбаатар, х 145.
- "Төв Монголын хээрийн бүсийн цөлжилтийн төлөв байдал, хүчин зүйлийн үнэлгээ, зураглал" суурь судалгааны тайлан. (2013). /ШУА Геоэкологийн хүрээлэн, ШУТС-ийн архив, Улаанбаатар, х 175.